## ОРХОН АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны 03 дугаар сарын 03 | Орхон аймаг

| № | Арга хэмжээ | Хугацаа | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага | Санхүүжилт /сая.төг/ | Хүрэх үр дүн | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **Зорилт 1. Судалгаа, мэдээ, тайлан гаргах** | | | | | | | |
| 1. | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын мэдээллийн сан бүрдүүлэх | Жилдээ | Аймгийн ЗДТГ ХБТХОХ | БОАЖГ, МХГ, ГХБХБГ, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ | - | Мэдээллийн сантай болсон байна. | Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй "Дайрга уул" ХХК-д аймгийн Засаг даргын 2024 оны А/174 дугаар захирамжаар Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл, "Сансарын эрин" ХХК-д Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг аймгийн Засаг даргын 2024 оны А/427 дугээр захирамжаар тус тус 15 жилийн хугацаатай олгосон.<br>Ашигт малтмал газрын тосны газрын уул уурхайн кадастрын компьютержсон систем https://cmcs.mrpam.gov.mn/cmcs-д 2024 онд Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон 2 аж ахуйн нэгжийн талбайн солбицлыг баталгаажуулсан. Мөн Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан болон тусгай зөвшөөрлийн жилийн төлбөрөө төлсөн аж ахуй нэгжийн мэдээллийг оруулж жилийн сунгалтыг хийсэн 2024 оны байдлаар Орхон аймагт ашигт малтмал ашиглалтын болон түгээмэл тархацтай ашигт малтмалын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 9, түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 7, ашигт малтмалын хайгуулын тусгай 5, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 2 орд байна.<br>Хэрэгжилт 100% |
| 2. | Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, хандив, дэмжлэгийн мэдээ гаргах | Улирал, жилээр | Аймгийн ЗДТГ СТСХ | Татварын хэлтэс, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ | - | Иргэдэд ил тод мэдээлэх ажил сайжирсан байна. | Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, хандив, дэмжлэгийн мэдээг МОҮИТБААлбанд хугацаанд нь хүргүүлэн ажилласан.<br>Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудаас орон нутгийн төсөвт төлж байгаа татвар, хураамж, торгууль зэрэг орлого болон аймаг, сумын ЗДТГ, төсөвт байгууллагад хандивлаж байгаа мөнгөн болон мөнгөн бус хөрөнгийн тайланг холбогдох маягтын дагуу Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсвийн орлого, хөрөнгө оруулалтын санхүүжилт хариуцсан мэргэжилтэн нь жил бүр гаргаж Erdenet.mn д байршуулж нийтэд мэдээлж, тайлагнан ажиллаж байна<br>Хэрэгжилт 100% |
| 3. | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖСайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу гүйцэтгүүлж, | Жилдээ | БОГ | ХБТХОХ, МХГ, ГХБХБГ, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ | - | Байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл буурна. | "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, БОАЖСайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, "Эрдмин" ХХК, "Ачит-Ихт" ХХК, "Зэс-Эрдэнийн хувь" ХХК, "Гал-сэнтий" ХХК, "Очир төв" ХХК, "Дэлт хошуу" ХХК-иудын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | батлуулан хэрэгжилтийг хангуулж ажиллах | | | | | | тавьж, дүгнэхэд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ 91.5%, "Ачит-Ихт" ХХК 91.5%, "Эрдмин" ХХК 90%, "Зэс-Эрдэнийн хувь" ХХК 94%, "Гал-Сэнтий" ХХК 88.1%, "Очир төв" ХХК 91.1 %, "Дэлт хошуу" ХХК 91.3%-тай тус тус дүгнэгдлээ. Хэрэгжилт 100% |
| 4. | Уул уурхайн үйлдвэрлэлийн нөлөөллийн бүсэд амьдарч байгаа айл өрх, иргэд, мал сүрэгт аюултай хог хаягдал, агаарын бохирдол, бусад сөрөг нөлөөллөөс үүсч буй хор хөнөөлийн талаарх мэдээ, судалгаа гаргах | Жилдээ | БОАЖГ, ЭМГ, Стандарт хэмжил зүйн хэлтэс | Аймгийн ЗДТГ, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд, "Эрдэнэт хүмүүний эв нэгдэл" ТББ, "Төр иргэн түншлэл" ТББ, иргэд | - | Судалгааны сан бий болсон байна. | Байгаль орчны шинжилгээний лаборатори нь гадаргын усны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн дагуу 2024 оны жилийн эцсийн байдлаар Хангал голын 4 цэгийн 48, Уртбулаг-Эрдэнэт гол 4, Чингэл-Эрдэнэт гол 4, Орхон голын 2 цэгийн 24 дээжид 23 үзүүлэлтээр нийт 80 дээжид 1840 удаагийн давталттай орчны чанарын хяналт-шинжилгээ хийж гүйцэтгэсэн. 2024 оны 1-р сард Орхон-Хангал доод цэг ёроолдож хөлдсөн тул дээж авах боломжгүй байсан. Шинжилгээний дүнгээр Хангал-Эрдэнэт гол 3-р зэрэг буюу бага бохирдолтой, Орхон гол 2-р зэрэг буюу Цэвэр, Уртбулаг-Эрдэнэт гол 3-р зэрэг буюу бага бохирдолтой, Чингэл-Эрдэнэт гол 2-р зэрэг буюу цэвэр түвшинд байна. Хяналт шинжилгээний дүн мэдээг ЦУОШГ-ын мэдээллийн сан болон БОХЗТ лабораторид сар бүрийн 1-ны дотор дамжуулж байна.<br>Мөн Орхон аймгийн УЦУОШТ-ийн http://orkhon.tsag-agaar.gov.mn/ сайт дээр сар бүрийн тайлан мэдээг оруулж ард иргэдэд мэдээлж байна.<br>Хаягдлын аж ахуйн хэсгийн ойр орчимд суурьшиж буй малтай иргэдэд үйлдвэрийн газрын Онцгой байдлын газар, Хуулийн хэлтэс, Баяжуулах үйлдвэр зэрэг бүтцийн нэгжүүдийн мэргэжилтнүүд хамтран албан |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шаардлага хүргүүлж мэдээллээр хангаж ажилласан.<br>Мөн Хаягдлын аж ахуйн хэсгийн бүсэд Дотоодыг хамгаалах 816-р ангитай гэрээ байгуулан хөдөлгөөнт /мотоциклтой/ байнгын 2 харуулыг тогтмол ажиллуулж байна.<br>Хэрэгжилт 90% |
| **Зорилт 2. Тайлан мэдээг иргэдэд нээлттэй, ил тод мэдээлэх** | | | | | | | |
| 5. | Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурвалжлага, мэдээ явуулах | Жилдээ | Хэвлэл мэдээллийн байгууллагууд, "Эрдэнэт хүмүүний эв нэгдэл" ТББ, "Төр иргэн түншлэл" ТББ | Аймгийн ЗДТГ БОГ | - | Мэдээлэл олон нийтэд хүрсэн байна. | "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Ачит Ихт" ХХК, "Эрдмин" ХХК, "Зэс эрдэнийн хувь" ХХК-ийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг үйлдвэрийн цахим хуудас, орон нутгийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдэд мэдээлэл тогтмол хүргэж байна.<br>Түгээмэл тархацтай ашигт малтмал, барилгын материалын ашиглалт, олборлолтын мэдээ, нөөцийн хөдөлгөөний мэдээллийг Ашигт малтмал, газрын тосны газрын чиглэл хариуцсан нэгжид улирал бүр хүргүүлэн ажиллаж байна. Мөн барилгын хөгжлийн төвд Орхон аймгийн барилгын материалын эрдэс, түүхий эдийн орд, илэрцийн мэдээллийг гарган хүргүүлсэн.<br>Үйлдвэрүүдийн хамтын ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд хийгдсэн арга хэмжээг Nomin Tv, Тусгал тв, Etv, Эрдэнэт инфо сайтуудаар дамжуулан сурталчилсан. Мөн Зэс фестиваль арга хэмжээний талаар Тусгал тв, Etv, Эрдэнэт инфо сайт, update.mn, Мэдээллийн бирж ТВ-ээр сурталчилсан.<br>Орхон аймаг, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ хамтран "Эрдэнэт шинэ илгээлт" төсөл хамтран хэрэгжүүлэх 55/24 дугаартай санамж бичиг 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан. "Эрдэнэт шинэ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | илгээлт" төсөл нь ирээдүйн Орхон аймгийн хөгжлийн тодорхойлох, Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хурдасгах, эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилготой бөгөөд төслийн талаар дэлгэрэнгүй танилцуулах уулзалтыг 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 25-ны өдрүүдэд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Соёл урлагийн цогцолборт зохион байгуулсан.<br>"ЭРДЭНЭТ-ШИНЭ ИЛГЭЭЛТ" төслийн танилцуулгыг УИХ-ын Тамгын газрын дэд дарга Ү.Амарбат, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Д.Мөнхбат, Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга С.Даваадорж болон "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Үйлдвэрлэл технологийн паркийн төслийн нэгжийн Тэргүүлэх инженер С.Гантулга нар хийсэн ба уулзалтад нийт 1300 албан хаагч, иргэд хамрагдлаа.<br>Хэрэгжилт 100% |
| **Зорилт 3. Хамтын ажиллагаа, түншлэл хөгжүүлэх, оролцогч талуудын чадавх бэхжүүлэх** | | | | | | | |
| 6. | Орхон аймаг, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Ачит-Ихт" ХХК, "Эрдмин" ХХК-тай байгуулсан хамтран ажиллах гэрээ, түүний хэрэгжилтийн тайланг нээлттэй тайлагнах | Жилдээ | Аймгийн ЗДТГ | Хэвлэл мэдээллийн байгууллагууд, "Эрдэнэт хүмүүний эв нэгдэл" ТББ, "Төр иргэн түншлэл" ТББ | - | Хамтран ажиллах гэрээнд иргэдийн зүгээс тавих хяналт, мэдээлэл сайжирч, холбогдох мэдээллээр хангагдана. | Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Ачит-Ихт" ХХК, "Эрдмин" ХХК-тай байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр 2021-2024 онд хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж ирсэн.<br>2024 онд "Зэс эрдэнийн хувь" ХХК-тай байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар шинээр гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.<br>2024 онд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-тай 3.0 тэрбум, "Эрдмин" ХХК-тай 87.6 сая, "Ачит-Ихт" ХХК-тай 160.0 сая, "Зэс |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эрдэнийн хувь" ХХК-тай 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хамтран ажиллах төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж, төлөвлөгөөг тухай бүр эрдэс баялгийн гэрээний мэдээллийн сан (www.iltodgeree.mn)-д мэдээлсэн. Мөн Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай байгуулсан "Ус ашиглуулах гэрээ"-г эрдэс баялгийн гэрээний мэдээллийн сан (www.iltodgeree.mn)-д байршуулсан.<br>Гэрээ, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж арга хэмжээний биелэлтийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухай бүр сурталчлан ажиллаж байна.<br>Хэрэгжилт 100% |
| 7. | Хуульд заасан мэдээллийг үнэн зөв гаргаж нийтэд мэдээлээгүй ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, тэдний гэрээт туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжид зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх | Жилдээ | БОГ | Аймгийн ЗДТГ | - | Мэдээллийг үнэн зөв мэдээлсэн байна. | Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 9 хуулийн этгээдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэж зөрчилтэй байсан "Зунрун" ХХК, "Гарпимимус" ХХК-ийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох арга хэмжээ авч, илэрсэн зөрчлийг арилгуулсан. Хэрэгжилт 90% |
| 8 | Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс орон нутгийн төсөвт 2023 онд төлж байгаа татвар, төлбөр, хураамж, торгууль зэрэг орлого болон аймаг, сумын ЗДТГ, | 4-р улиралд | Аймгийн ЗДТГ СТСХ | Татварын хэлтэс, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд | - | Мэдээллийг үнэн зөв, хугацаанд нь мэдээлсэн байна. | Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтын хүрээнд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй томоохон аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулах, гэрээний хүрээнд жил бүр хамтын ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.<br>2017 оноос хойш "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-тай 16.7 тэрбум, "Эрдмин" ХХК-тай 421.2 сая, "Ачит-Ихт" ХХК-тай 1.6 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төсөв- байгууллагад хэндизлаж байгаа мөнгөн болон мөнгөн бус хөрөнгийн тайланг холбогдох маягтын дагуу жил бүр гаргаж нийтэд мэдээлэх, журмын дагуу тайлагнах | | | | | | тэрбум, "Зэс эрдэнийн хувь" ХХК-тай 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хамтран ажиллах төлөвлөгөө баталж аймаг орон нутгийн хэмжээнд томоохон хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтыг хамтран хийж, хэрэгжүүлж байна.<br>2024 оны хамтын ажиллагааны томоохон арга хэмжээнүүдээс дурдвал:<br>"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-тай хамтран 1.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар төрийн өмчийн 17 сургуулийн 1-5-р ангийн 11300 хүүхдийн үдийн хоолны 1 хүүхдэд ноогдох зардлыг 1385 төгрөгөөр нэмэгдүүлж 2835 төгрөг болгосон. Цагаан тоосны дэгдэлтийн нөлөөллөөс тоосны бүсэд амьдарч буй иргэдийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд Говил, Баянцагаан багийн сургууль, цэцэрлэг, Жаргалант сумын сургууль цэцэрлэг, сурагчдын дотуур байрны цонхонд PM2.5 нарийн ширхэгт тоос, тоосонцор, хорт утааг 95%-аас дээш шүүх чадвартай солонгос нано шүүлтүүр, тоосны тор суурилуулсан.<br>"Ачит-Ихт" ХХК нь боловсролын салбарт хөрөнгө оруулалт хийж ерөнхий боловсролын 6 сургуульд тус бүр 1 химийн кабинетыг засварлан иж бүрэн тохижуулж, химийн хичээлээр анги нийтийн хамарсан масс олимпиад, спорт, урлагийн томоохон тэмцээн уралдааныг ивээн тэтгэж санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.<br>"Эрдмин" ХХК Бусийн оношилгоо эмчилгээний төвд нярайн тасагт хүүхдийн шарлалтыг бууруулах болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжийг олгож, 27-р цэцэрлэгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн анги |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | танхимыг тохижуулж өгсөн. Гадаад дотоодын зочид төлөөлөгчид хүндэтгэл үзүүлэх аймгийн онцлогийг илтгэсэн зэсээр хийсэн бэлэг дурсгалын зүйл /зэс мөнгөний мод, таваг, уртасгагч залгуур/ нийлүүлээд байна.<br>"Зэс Эрдэнийн хувь" ХХК физикийн хичээлээр масс олимпиад ивээн тэтгэж зохион байгуулах, ЕБС-д физикийн кабинет байгуулах ажлыг хийж байна.<br>Хамтын ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор орон нутгийн аж ахуйн нэгжүүдээс "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ жилд 12.0 тэрбум, бусад аж ахуйн нэгж 1.0 тэрбумаас доошгүй төгрөгийн худалдан авалтыг хийж байна.<br>Хэрэгжилт 100% |
| 9. | Срон нутагт үйл ажиллагаа явуулж буй хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах, дэд зөвлөлийг чадавхжуулах сургалт зохион байгуулах | Жилдээ | Аймгийн ЗДТГ | БОГ | - | Үйл ажиллагаан ы хяналт сайжирна. | Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн Дэд зөвлөлийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор 2024 онд "Эрдэнэт хүмүүний эв нэгдэл" ТББ-тай 2.5 сая төгрөгийн гэрээ байгуулж 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр ОҮИТБС-ын Ажлын албаны Орон нутаг хариуцсан мэргэжилтэн Б.Хосбаяр манай аймагт ирж цахим болон танхимын сургалтыг хамтран зохион байгуулсан. ОҮИТБС-ын Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, Мэдээлэл технологийн зөвлөх С.Болор-Эрдэнэ, Орон нутаг хариуцсан мэргэжилтэн Б.Хосбаяр нар цахимаар "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ач холбогдол" ба ОҮИТБС-ын шинэчилсэн цахим тайлангийн системийн танилцуулга, "Дэд зөвлөлүүдийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гэрээний хэрэгжилтийг хянах аргачлал, үйл ажиллагааны сайн туршлага"-ын талаар тус тус танилцуулсан. Мөн "Эрдэнэт Хүмүүний Эв Нэгдэл" ТББ тэргүүн Б.Батцэцэг Орон нутаг дахь дэд зөвлөлийн зорилго, дүрмийн тухай ойлголтын талаар мэдээллийг өгсөн.<br>Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн Дэд зөвлөлийн чадавхыг бэхжүүлэх талаар анх удаа орон нутагт сургалт зохион байгуулсан.<br>Хэрэгжилт 100% |
| 10. | Жил бүрийн ажлын төлөвлөгөө, тайланг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ажлын албанд хүргүүлэх | Жилдээ | Аймгийн ЗДТГ | ОҮИТБС-ын дэд зөвлөл | - | Төлөвлөгөө, тайланг хугацаанд нь хүргүүлсэн байна. | Аймгийн олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, биелэлтийг хугацаанд нь гарган ОҮИТБС-ын ажлын албанд хүргүүлэн ажиллаж байна.<br>Хэрэгжилт 100% |
| ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ | | | | | | | 98.0% |

ТАНИЛЦСАН: ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН

ХЭЛТСИЙН ДАРГА С.ДАВААДОРЖ

ТАЙЛАГНАСАН: ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН У.ЧИГЭСТЭЙ